БМҮ ЗӨВЛӨЛ

# Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр:

**Мандах их сургуулийн Мэдээлэл, технологийн сургууль**

Хөтөлбөрийн нэр: **Программ хангамж**

Индекс: 061302 бакалавр

Шинжээчийн баг:

| | |
|---|---|
| Ахлагч: | Н.Эрдэнэхүү<br>/ШУТИС-ийн МХТС-ийн сургалт, чанарын албаны дарга/ |
| Гишүүд: | Н.Нямаа<br>/ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн профессорын багийн ахлагч/<br>Б.Энхтуул<br>/МУИС-ийн ХШУИС-ийн Мэдээлэл, компьютерын ухааны тэнхимийн дэд профессор/ |

2022.12.24

# Агуулга


**I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

**II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

**III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

**IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

# I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<table>
<tr><td>Сургуулийн нэр /Монгол, Англи/</td><td colspan="2">Мандах их Сургуулийн Мэдээллийн Технологийн Сургууль<br>/School of Information Technology, Mandakh University/</td></tr>
<tr><td>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</td><td colspan="2">Программ хангамж<br>/Software Engineering/</td></tr>
<tr><td>Индекс</td><td colspan="2">061302</td></tr>
<tr><td>Шинжээчид</td><td colspan="2">1. Н.Эрдэнэхүү<br>/ШУТИС-ийн МХТС-ийн сургалт, чанарын албаны дарга/<br>2. Н.Нямаа<br>/ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн профессорын багийн ахлагч/<br>3. Б.Энхтуул<br>/МУИС-ийн ХШУИС-ийн<br>Мэдээлэл, компьютерын ухааны тэнхимийн дэд профессор/</td></tr>
<tr><td>Зохицуулагч</td><td colspan="2">Б.Оюунчимэг /Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч/</td></tr>
<tr><td rowspan="10">Төлөвлөгөө</td><td>Он сар өдөр</td><td>Хийгдсэн байх ажлууд<br>/Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/</td></tr>
<tr><td>11/25</td><td>Шинжээчийн багийг томилсон.</td></tr>
<tr><td>11/28</td><td>Шинжээчидтэй гэрээ байгуулсан.</td></tr>
<tr><td>11/29</td><td>Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгсөн.</td></tr>
<tr><td>12/06</td><td>Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.</td></tr>
<tr><td>12/15, 16</td><td>Шинжээчид сургууль дээр очиж ажилласан.</td></tr>
<tr><td>12/26</td><td>Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.</td></tr>
<tr><td>12/27</td><td>Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авсан.</td></tr>
<tr><td>12/29</td><td>Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэсэн.</td></tr>
<tr><td>2023.01 сар</td><td>Мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.</td></tr>
</table>

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Мандах Их Сургууль нь 1992 онд байгуулагдсан хувийн хэвшлийн анхны сургуулиудын нэг бөгөөд 2022 оны байдлаар 5 бүрэлдэхүүн сургуультай, 2300 гаруй оюутантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.
Бүрэлдэхүүн сургуулиудын нэг нь Мэдээллийн технологийн сургууль бөгөөд 2006 оноос тэнхмийн зохион байгуулалтаар, 2017 оноос бие даасан сургууль болж үйл ажиллагаа явуулж ирсэн байна. Тус сургууль 16 жилийн хугацаанд программ хангамж мэргэжлээр 200 гаруй, мэдээллийн систем мэргэжлээр 180 гаруй бакалаврын зэрэгтэй төгсөгч бэлтгэсэн байна. 2022 он байдлаар 155 оюутан идэвхтэй суралцаж байна.
Программ хангамж хөтөлбөрийг хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд анх удаа оруулахаар өөрийн үнэлгээний тайлан ирүүлсэн бөгөөд хөтөлбөрийн зорилго, боловсролын зорилт, суралцахуйн үр дүнг дараах байдлаар тодорхойлсон байна.

**Зорилго:**
Үндэсний болон олон улсын дээд боловсролын стандарт, ажил олгогчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн, хөрвөх чадвартай, программ хангамжийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн мэдлэгтэй, ёс зүйтэй, харилцааны өндөр ур чадвартай, гадаад хэлний мэдлэг, чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд чиглэнэ.

**Хөтөлбөрийн боловсролын зорилтууд (PEO-Program Educational Objectives):**
**Зорилт 1:** Зах зээлийн эрэлт хэрэгцээ, улс орны хэтийн төлөвлөлтөд нийцүүлсэн бүтээлч сэтгэлгээтэй, мэдээлэл технологийн шинэ бүтээгдэхүүнийг ашиглах, дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдлэг чадвар хандлагыг эзэмшсэн мэргэжилтэн бэлтгэх,
**Зорилт 2:** Мэдээлэл технологийн салбарын сургалт судалгаа инновацад суурилсан үйлчилгээгээр дамжуулан мэргэжилтэн, судлаачдад эзэмшсэн боловсролоо дээшлүүлэх, шинэ бүтээгдэхүүн, шинэ зах зээл хөгжүүлэх хандлагад чиглүүлэх
**Зорилт 3:** Сургалтын арга зүйн хувьд хичээлээр сурсан зүйлээ практик дээр сурч, дадлагажих арга барилд чиглүүлэх
**Зорилт 4:** Дотоодын төрийн болон бизнесийн байгууллагууд, программ хангамж үйлдвэрлэгч байгууллагуудын шаардлага хангахуйц мэдлэг, чадвар, дадлыг эзэмшүүлэх
**Зорилт 5:** Багаар ажиллах, манлайлах, ёс зүйтэй, өөрийгөө илэрхийлэх чадвар, хандлагад чиглүүлэх

**Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд(PLOs-Program Learninig Outcomes):**

**1. Программ хангамж хөтөлбөрөөр эзэмших мэдлэг:**

1.1. Дээд боловсролтой мэргэжилтний зайлшгүй мэдвэл зохих хүмүүнлэг, нийгмийн ухаан, математик статистик, мэдээллийн систем зэрэг ерөнхий эрдмийн суурь мэдлэгтэй,
1.2. Суурь шинжлэх ухааны үндсэн ухагдахууны асуудлуудыг судлах оновчтой мэдлэгтэй,
1.3. Компьютерын техникийн үндэс, сүлжээ, алгоритм, өгөгдөл, өгөгдлийн дүрслэл, өгөгдлийн бүтэц, үйлдлийн систем, программчлалын хэлний суурь мэдлэгтэй,
1.4. Программ хангамжийн чанар, зохиомж, тестчлэл, автоматжуулалтын тохирох хэрэгслийг ашиглаж сурах мэдлэгтэй,
1.5. Программчлалын технологиуд болох процедур хандалтат, объект хандалтат технологи, ялгаа болон давуу талууд, класс, хийсвэрлэл, ондоошил, битүүмжлэл, удамшлын мэдлэгтэй,
1.6. Веб хөгжүүлэх HTML, CSS, JavaScript, Django framework, .Net framework, React, -ийн талаарх мэдлэгтэй,
1.7. Өгөгдлийн бүтэц зохион байгуулалт, түүн дээр боловсруулалт хийх SQL хэл, өгөгдлийн сангийн үндсэн ойлголт болон боломжууд, өгөгдлийн санг удирдах хянах, хамгаалах мэдлэгтэй,
1.8. Гар утасны апп хөгжүүлэх суурьмэдлэгтэй,

**2. Програм хангамж хөтөлбөрөөр эзэмших ур чадвар**

2.1. Мэргэжлийн хүрээнд судалгаа, шинжилгээний ажил хийх, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах,

2.2. Багийн зохион байгуулалтаар ажиллах, асуудал шийдвэрлэх,

2.3. Компьютерын зохион байгуулалт, ажиллах зарчим, өгөгдөл хадгалагдах хэлбэр, удирдлагын үйлдлүүд,программчлалын хэл дээр програм бичих үндсэн чадваруудыг эзэмших, асуудлыг шийдвэрлэх алгоритм зохиох,

2.4. Веб сайт хөгжүүлэх, сервер дээр байрлуулах, тохиргоо хийж гүйцэтгэх,

2.5. Компьютерын үйлдлийн системийн орчинд ажиллах, суулгах, тохиргоо хийх, линукс төст үйлдлийн систем дээр ажиллах, гар утасны апп хөгжүүлэх, програм хөгжүүлэх,

2.6. Өгөгдлийн санг боловсруулах, системийг шинжлэх, зохиомжлох, хэрэглэгчийн шаардлагад тохирсон бичиг баримт боловсруулах, UML 2 буюу объект хандалтат систем хөгжүүлэх арга, төслийг удирдах, чанар түүнийг үнэлгээг тооцох, ашиглах,

2.7. Байгууллагын болон нийгмийн хүрээнд хэрэгцээ шаардлагад нийцсэн аливаа бүтээгдэхүүн, систем, үйл ажиллагааны инженерийн шийдэл гаргах, төлөвлөх, хэрэгжүүлэх

**3. Програм хангамж хөтөлбөрөөр төлөвших хандлага**

3.1. Ажлын байранд аливаа асуудалд ёс зүйтэй, хариуцлагатай, үнэнч шударга зарчимч байх,

3.2. Аливаа зүйлийг логик дэс дараалалтай сэтгэх,

3.3. Бие хүний төлөвшлийн болон бүтээлч сэтгэлгээгээр өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх,

3.4. Хувь хүний болон мэргэжлийн, судлаачийн ур чадвараа ямагт хөгжүүлэн судалгаа шинжилгээний олон талт, нарийн төвөгтэй, дэвшилтэт арга зүй, дэвшилтэт технологийг ашиглах, судалгааны ажилд нэвтрүүлэх, үр дүнг бусдад илэрхийлэх,

**Сургалтын төлөвлөгөөний бүтэц:**

Програм хангамж хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө нь дараа бүтэцтэйгээр боловсруулагдсан байна.

| | Заавал судлах хичээлийн | | Сонгон судлах хичээлийн | | Нийт судлах хичээлийн | |
|---|---|---|---|---|---|---|
| Хичээлийн төрөл | кредит | хувь | кредит | хувь | кредит | хувь |
| Ерөнхий суурь хичээл | 29 | 32.2% | 9 | 23.1% | 38 | 29.5% |
| Мэргэжлийн суурь хичээл | 18 | 20.0% | 12 | 30.8% | 30 | 23.3% |
| Мэргэшүүлэх хичээл | 43 | 47.8% | 18 | 46.2% | 61 | 47.3% |
| Нийт дүн | 90 | 100.0% | 39 | 100.0% | 129 | 100.0% |

**Хөтөлбөрийн хичээлийн онол, практикийн харьцуулалт:**
Сургалтын төлөвлөгөөнд туссан мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдийн лабораторийн сургалтаар оюутнуудад дадлага олгохоос гадна мэргэжлийн дадлага, программ хангамжийн төсөл, программ хангамжийн бакалаврын төгсөлтийн ажил зэрэг практик дадлага олгох хичээлүүдийг 10 кредитээр сургалтын төлөвлөгөөнд тусгасан байна.

**Хөтөлбөрийн онцлог:**

- ✓ 2006 оноос хойш 16 жил программ хангамж, мэдээллийн систем хөтөлбөрөөр сургалт зохион байгуулж 2018 оноос бие даасан сургуулийн түвшинд тогтвортой үйл ажиллагаа явуулж буй хувийн сургуулиудын нэг болж чадсан байна.
- ✓ Мандах их сургуулийн хөгжлийн стратеги төлөвлөгөөг 5 жилээр боловсруулж хэрэгжүүлж ирсэн байна. Энэ хүрээнд e-mandakh цахим төлөвлөлтийн систем (ERP) хөгжүүлж, ашиглаж эхэлж байгаа нь онцлог ажил болсон байна.
- ✓ 2017 онд ISO 9001:2015 гэрчилгээ, 2020 онд ISO 21001:2018 чанарын удирдлагын тогтолцоог тус тус хэрэгжүүлж гэрчилгээ авсан Монголын анхны хувийн сургууль болсон нь онцлог үзүүлэлт юм.
- ✓ Тусдаа хичээлийн байртай, цөөн оюутантай учраас анги танхим, лаборатори хүрэлцээтэй, сургалтын орчин оюутан суралцагсдын хэрэгцээ шаардлагад нийцдэг, интернэтийн хурд, хамрах хүрээ хангалттай зэрэг орчин талд шаардлага хангасан байна.

  программчлалын клубээр дамжуулан оюутнуудад практик дадлага эзэмшүүлэх, багаар ажиллах, бие биенээсээ суралцах болон бодит төслүүд дээр багш нартайгаа хамтарч ажиллах боломж олгодог сайн туршлага байна.
- ✓ Хичээлийн улирлын шалгалтыг MOODLE системийн тестийн санд тулгуурлан багшийн оролцоогүйгээр зохион байгуулдаг, бүтээлийн хуулбарлалт шалгах программаар зарим хичээлийн бие даалт, төгсөлтийн ажлыг шалгаж үнэлдэг онцлог байна.
- ✓ Сургалтын төлбөр төлөх уян хатан системтэй, сурлагын амжилтаас хамааруулан захирлын нэрэмжит тэтгэлэг, хөнгөлөлтүүд олгодог нь суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагаа болдог.
- ✓ Суралцагчдын тоо цөөн, багш оюутнуудтай мөн тэдний эцэг эхчүүдтэй илүү хамтран ажиллах боломж бүрдсэн бөгөөд энэ нь оюутнуудын хандлага төлөвшлийг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг давуу тал байна.

  вебээр дамжуулан файл менежмент, бүтээлч санаа авах, талархал хүргэх, мэдээлэл солилцох зэрэг боломжуудыг багш оюутнуудад олгосон байна.
- ✓ Багш нар тогтвор суурьшилтай ажилладаг, тэдэнд ажилласан жил, ажлын гүйцэтгэлээр нэмэгдэл цалин олгодог. Мөн цалингийн зээл олгох, буцалтгүй тусламж үзүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээ авахад жил бүр багагүй мөнгө төсөвлөж зарцуулдаг.
- ✓ Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч сургууль нь санхүүгийн хувьд бие даасан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд жилийн төсөв, зарцуулалтын тайланг гаргадаг. Хугарлын цэгийн шинжилгээг тооцож санхүүгийн төлөвлөлтөд ашигладаг.
- ✓ Оюутан суралцагсад улсын чанартай программчлалын олимпиадад амжилттай оролцож байгаа нь тэдний мэдлэг чадвар, бусад их, дээд сургуулийн ижил мэргэжлийн оюутнуудтай өрсөлдөх түвшинд хүрч байгаа харуулж байна.

## III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

## Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

*Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.*

**1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**
Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

**Илрэл нотолгоо:**
Хөтөлбөрийн шинэчлэлд дараах үндэсний олон улсын жишиг бичиг баримтуудыг ашигласан байна. Үүнд:

- Монгол Улсын Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2014 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-д нийцүүлэн 12 бүлэгтэйгээр сургалтын хөтөлбөрийг боловсруулсан байна.
- ACM байгууллагаас санал болгосон CC2020, Software Engineering 2014 жишиг хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа хийж хөтөлбөрийн нийцэл 90.68% байгааг тогтоосон байна.
- Тэр дундаа Computing essentials, Professional Practice, requirements analysis and specification (REQ), software design (DES), Software process, mathematical and engineering fundamentals, software quality (QUA) гэсэн 5 чиглэлээр илүү нийцтэй, “security (SEC)”, software verification & validation (VAV), software modeling and analysis, software design гэсэн чиглэлийн хичээлүүдийн агуулга ACM жишиг хөтөлбөрт санал болгосон стандартаас бага байгааг тогтоосон байна.
- Мөн сургалтын хөтөлбөрийг сайжруулах зорилгоор STEEP шинжилгээ хийснээс гадна МУИС, ШУТИС, АНУ-ын Миссисипи Их Сургуулийн хөтөлбөртэй тус тус харьцуулсан судалгаа хийж Миссипи Их Сургуулийн сургалтын төлөвлөгөөнд тусгасан 34 хичээлийн 91% нь программ хангамжийн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд тусгасан хичээлүүдтэй ижил, дүйцэхүйц байгааг тогтоосон байна.

**Онцлог зүйл:**

- Хөтөлбөрт тусгасан хичээлүүдийг ACM байгууллагаас санал болгосон CC2020, Software Engineering 2014 жишиг стандартуудтай харьцуулсан судалгаа хийж агуулгын нийцлийг тогтоосноос гадна цаашид аль чиглэлд хэрхэн сайжруулах шаардлагатайг тогтоосон нь чухал ажил болсон байна.

**Зөвлөмж:**

- Нэгэнт олон улсын стандартад нийцүүлэхээр зорьж байгаа бол суралцахуйн үр дүн талаас нь мөн харьцуулалт хөтөлбөрийн 19 суралцахуйн үр дүнг хэрхэн шинэчлэх талаар дүн шинжилгээ хийх нь зүйтэй.

**Шалгуурыг хангасан байдал: <u>Бүрэн хангасан</u>**

**1.2 Хөтөлбөрийн зорилго**
Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

**Илрэл нотолгоо:**

- Мандах их сургуулийн 2017-2022 оны стратеги төлөвлөгөөний 6 зорилттой уялдаатайгаар хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлсон байна.
- Программ хангамж хөтөлбөрийн боловсролын зорилтууд(PEOs)-ыг 5 чиглэлээр, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд(PLOs) буюу оюутны эзэмших мэдлэг, чадвар, хандлагын жагсаалтыг 19 үзүүлэлтээр тус тус тодорхойсон байна.
- Мөн PEOs ба PLOs хоорондын хамаарлыг гаргаж сургалтын төлөвлөгөөнд тусгасан байна.
- Суралцагч 4 жилийн хугацаанд курс бүрт ямар мэдлэг, ур чадвар, хандлага голлон эзэмшихийг тодорхойлж үүнд чиглүүлсэн хичээлийн хөтөлбөр боловсруулахыг зорьсон байна.

**Зөвлөмж:**

- Суралцахуйн үр дүнгүүдийг мэдлэг чадвар, хандлага гэсэн ангилалаар тодорхойлсон хэдий ч эдгээр чадамжуудыг Блүмийн таксаном дагуу үйлийн түвшнээр нарийвчлан тодорхойлох шаардлагатай гэж үзэж байна.

**Шалгуурыг хангасан байдал: <u>Бүрэн хангасан</u>**

**1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Тус сургуульд нэвтрүүлсэн ISO стандартын дагуу MU-PD-3:2021DS дугаар бүхий хөтөлбөрийн цогц бичиг баримтыг 12 бүлгийн дагуу боловсруулж 2021 оны 12 сарын 20-ны эрдмийн зөвлөлийн хурлаар батлуулсан байна.
- Сургалтын төлөвлөгөөнд туссан хичээлүүдийн хөтөлбөрийг "Мандах их сургуулийн хичээлийн хөтөлбөр боловсруулах журам"-ын 2014, 2016, 2018, 2020 онуудад тус тус шинэчлэн боловсруулж ба улиралд бүр агуулга, арга зүйн хүрээнд тодорхой шинэчлэлүүд хийж ирсэн байна.
- Хичээлийн хөтөлбөрийг хичээлийн танилцуулга, сургалтын арга зүй ба сурахуйн үйл ажиллагаа, хичээлийн суралцахуйн үр дүн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн хамаарал агуулын хүрээнд боловсруулахдаа үнэлгээний рубрикийг хичээлийн хөтөлбөрт тусгасан байна.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөр төлөвлөлтөд оролцогч талууд, ялангуяа төгсөгчид, ажил олгогчид, мэргэжлийн холбоодын санал, зөвлөмжийг тусгах талд анхаарах, энэ талаар өгсөн санал зөвлөмжийг баримжуулж нотлох баримт бүрдүүлж байх

**Шалгуурыг хангасан байдал: <u>Бүрэн хангасан</u>**

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: <u>Бүрэн хангасан</u>**

## Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

*Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.*

**2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**
Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг 2006, 2009, 2011, 2014, 2021 тус тус шинэчилэн сайжруулсан байна.
- 2021 онд батлагдсан төлөвлөгөө нь 129 кредит бөгөөд агуулгын харьцаа БШУЯ-ны А/174 тушаалаар батлагдсан 30:25:45 харьцааг хангаж байна.
- Сургалтын төлөвлөгөөний нийт 129 кредитийн 39 нь сонгон суралцах буюу 3 түвшинд 9, 12, 18 кредитээр тус тус төлөвлөгдсөн байна.
- Сургалтын төлөвлөгөөнд туссан хичээлүүдийг курс бүрээр ангилан хөтөлбөрийн 19 суралцахуйн үр дүнтэй ямар хамааралтай байгааг матриц хэлбэрээр боловсруулан гаргасан байна. Мөн хичээл хоорондын хамаарлын модыг зураглан үзүүлсэн байна.

**Зөвлөмж:**

- Мэргэжлийн суурийн сонгон суралцах хичээл бараг бүгд санхүү, менежмент чиглэлийн хичээл байгаа тул энд мэргэжлийн хичээл нэмж оруулах

- Удирдлага мэдээллийн системээр оюутан хичээл сонгох боломж бүрдээгүй, аль нэг багшид шууд хуваарилагдаж байгаад анхаарч ажиллах

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**2.2 Сургалтын арга зүй**
Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хичээлийн хөтөлбөрт сургалтын арга зүйг тусгаж төлөвлөсөн.
- Оюутан төвтэй, тонгоруу анги гэх мэт сургалтын идэвхтэй арга зүйг голлон ашиглаж ирсэн байна.
- Тайланд тусгасан хичээлд ашиглаж байгаа сургалтын арга зүйн төлөвлөлтийг хичээлийн хөтөлбөрийг үнэлэхдээ баталгаажуулсан.
- Мөн сургалтын чанарыг сайжруулах зорилгоор нээлттэй, үзүүлэн хичээл зохион байгуулж ирсэнийг үр дүнгийн тайлангаар хянаж баталгаажуулсан.
- Сургалтыг танхимд зохион байгуулахдаа үзүүлэн материал бэлтгэн прожектор ашиглан оюутнуудад хүргэдэг.
- Цахим сургалтыг MOODLE платформ ашиглан зохион байгуулж ирсэн байна.

**Зөвлөмж:**

- Цаашид сургалтын олон шинэ арга зүй нэвтрүүлэх

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**2.3 Суралцагчийн үнэлгээ**
Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Суралцагчийн чадамжийн хүрсэн түвшинг хичээл бүрээр 100 оноогоор дүгнэж байна. Ингэхдээ хичээлийн хөтөлбөрт тусгасны дагуу рубрик үнэлгээ ашиглаж байна.
- Улирлын шалгалтыг авахдаа багшийн оролцоогүйгээр тестийн сан ашиглан MOODLE системээр хөндлөнгийн тест байдлаар зохион байгуулдаг онцлог байна.
- Программ хангамж хөтөлбөрөөр суралцагчдын сурлагын амжилт, чанарын сүүлийн 5 жилийн үзүүлэлтээс харахад амжилт 97%-аас доошгүй, чанар 68%-аас доошгүй гаргасан байна.

**Зөвлөмж:**

- Хичээлийн үнэлгээ нь хөтөлбөрт тусгаснаар рубрик ашиглан хийгдэж байгаа боловч хичээлээр төлөвлөсөн суралцахуйн үр дүнг үнэлж чадахгүй байгаа учраас энэ чиглэлд арга аргачлал боловсруулан хэрэгжүүлэх

**Шалгуурыг хангасан байдал:** **<u>Бүрэн хангасан</u>**

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:** **<u>Бүрэн хангасан</u>**

## Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

*Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.*

**3.1 Сургалтын орчин**
Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Мандах ИС-ийг 2017-2022 онд хөгжүүлэх Стратеги төлөвлөгөө
- Стандартад нийцсэн 940 мкв талбай бүхий хичээлийн байр, оюутны дотуур байр, спорт заал, номын сантай
- 64 компьютер бүхий 3 лаборатори, 14 компьютерын нөөцтэй
- Хичээлийн байр, сургалтын орчин, интернэт үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын цахим орчныг сайн бүрдүүлсэн
- Сүүлийн 5 жилд хийгдсэн ажлын тайлангууд
- Өөрийн үнэлгээний тайлан

**Онцлог зүйл:**

- Цөөн оюутантай тул танхим, лабораторийн хүрэлцээ сайн
- Мобинетын 30MB хурдтай WI-FI интернетэд холбогдсон, интернэтийн хурд, хамрах хүрээ хангалттай
- SANDBOX клубт зориулан анги танхим гаргаж тохижуулсан

**Анхаарах асуудал:**

- Мэргэжлийн ангийн оюутнуудад зориулсан өндөр хүчин чадал бүхий лабораторитой болох

**Зөвлөмж:**

- Сургалтын орчинг сайжруулах, сургуулийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд дотоодын болон гадны хөрөнгө оруулалт татахад санаачилга гаргаж ажиллах
- Стандарт шаардлага хангасан өрөөнд серверийн тоног төхөөрөмжийг байршуулах

**Шалгуурыг хангасан байдал: <u>Бүрэн хангасан</u>**

**3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**
Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Мандах ИС-ийг 2017-2022 онд хөгжүүлэх Стратеги төлөвлөгөө
- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- 37 хичээлийн материалыг online.mandakh.org вебэд байршуулсан
- Moodle системийг цахим сургалтад ашигладаг

**Онцлог зүйл:**

- Ихэвчлэн нээлттэй эхийн программ хангамж ашигладаг
- Сургуулийн серверт 700 гаруй видео хичээл, англи, монгол цахим ном байршуулсан
- Цахим шалгалтын тестийн сан бүрдүүлсэн
- Лабораторийн аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж ажилладаг

**Анхаарах асуудал:**

- Компьютероос гадна хичээл сургалтын үйл ажиллагаанд хэрэгцээтэй нэмэлт тоног төхөөрөмж, хэрэгслүүдийг авах, оюутнуудад тэдгээрийг ашиглах ур чадвар эзэмшүүлэх
- Сургалтад ашиглаж байгаа программ хангамжуудыг лицензжүүлэх тал дээр анхаарах

**Зөвлөмж:**

- Лабораторийн компьютерын хүчин чадлыг нэмэгдүүлэх
- Судалгаа хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр багшийг хангах
- Сургалтад хэрэглэгдэх лицензтэй программ хангамжийн тоог нэмэгдүүлэх

**Шалгуурыг хангасан байдал: <u>Бүрэн хангасан</u>**

**3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**
Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Мэдээлэл, технологийн сургуулийн 2017-2022 оны үйл ажиллагааны төсөв, зарцуулалтын тайлан
- Мэдээлэл, технологийн сургуулийн 2017-2022 оны үйл ажиллагааны зардлын задаргаа

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Номын фонд бүрдүүлэлтийн талаар тэнхим, багш нараас авсан судалгаа
- Номын сангийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангууд

**Онцлог зүйл:**

- Электрон каталог, номын бүртгэл, уншигч болон үйлчилгээний бүртгэл зэргийг агуулсан LIB4U.NET номын сангийн программ хангамжтай
- Жил бүр мэргэжлийн сурах бичгийн баяжилт хийгдэхэд зориулсан тодорхой санхүүжилттэй
- Багш нарын бичсэн ном сурах бичиг хэвлүүлэх зардлыг жилийн төсөвт тусгаж өгдөг

**Анхаарах асуудал:**

- EBSCO, Springer гэх мэт цахим санг албан ёсны эрхтэйгээр авч хэрэглэх
- Мэргэжлийн ном сурах бичгийн тоог нэмэгдүүлэх

**Зөвлөмж:**

- Сүүлийн үед хэвлэгдсэн мэргэжлийн ном сурах бичгийн тоог нэмэгдүүлэх
- Хөтөлбөрийн багш нар заадаг хичээлд ашиглах сурах бичиг, гарын авлага бичиж хэвлүүлэх

**Шалгуурыг хангасан байдал: <u>Бүрэн хангасан</u>**

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: <u>Бүрэн хангасан</u>**

## Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

*Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.*

**4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Мандах ИС-ийг 2017-2022 онд хөгжүүлэх Стратеги төлөвлөгөө
- Мандах ИС-ийн Хөтөлбөрийн хорооны ажиллах журам
- Мандах ИС-ийн Бакалаврын сургалт эрхлэхэд баримтлах журам
- Мандах ИС-ийн Сургалтын төлөвлөгөө боловсруулах, өөрчлөлт оруулах, батлах журам
- Мандах ИС-ийн Оюутны мэдлэг, чадварыг үнэлэх журам
- Хөтөлбөрийн хороо, дэд хорооны хурлын тэмдэглэлүүд
- Мэдээлэл, технологийн сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангууд
- Мэдээлэл, технологийн сургуулийн Сургалтын үйл ажиллагааны судалгаа \2017-2022\
- Мэдээлэл, технологийн сургуулийн “Программ хангамж” хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан

**Онцлог зүйл:**

- Мандах ИС-ийн Стратеги төлөвлөгөө, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалтыг батлагдсан дүрэм, журмын хүрээнд багаар ажиллах чадвартай, эвсэг хамт олон хэрэгжүүлдэг.

- Хөтөлбөрийн оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгааг жил бүр тогтмол авч судалгааны үр дүнд тулгуурлан хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулдаг. Цаашид хөтөлбөрийн сайжруулалтыг хийхэд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг ажлын төлөвлөгөөтэй хамт батлуулдаг нь тухайн төлөвлөсөн ажил биелэх боломжийг бүрдүүлдэг.
- Хөтөлбөрт суралцагч талаас ирсэн санал, гомдлыг шийдвэрлэдэг механизм бүрдсэн.
- Оролцогч талуудад хөтөлбөрийн талаарх мэдээллийг өгөх 3 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж мэдээллийн тасралтгүй урсгалыг хангадаг.

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн үйл ажиллагааны тайланг боловсруулахдаа хүрсэн үр дүн, хэрэгжээгүй ажлын шалтгааныг тодорхойлох дүн шинжилгээ хийх
- Хөтөлбөрт оролцогч талууд нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр тогтмол ажил зохион байгуулж хэвшсэн.

**Зөвлөмж:**

- Сургалтын албаны болон хөтөлбөрийн багш нарт зориулан албан бичиг баримт боловсруулалтын сургалтыг явуулах
- Албан бичиг баримт боловсруулалтын стандарт, шаардлагыг хангах

**Шалгуурыг хангасан байдал: <u>Бүрэн хангасан</u>**

**4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Мандах ИС-ийн хамтын ажиллагаатай байгууллагуудтай байгуулсан гэрээ
- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт /багш, суралцагчдын зүгээс/
- Төгсөгчдийн холбооны дүрэм
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангууд
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл
- Sandbox программчлалын клубийн үйл ажиллагааны тайлангууд

**Онцлог зүйл:**

- Мандах ИС нь хамтын ажиллагаатай гадаадын их сургуулиудтай хамтарч 2 жил тутамд Олон улсын ЭШХ зохион байгуулж багш нарын судалгаа, шинжилгээний ажлыг дэмждэг.
- Хөтөлбөрийн багш нарыг гадаад, дотоодод богино хугацааны сургалтуудад хамрагдахад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Тухайлбал: хэдийгээр сүүлийн 2 жилд цар тахлын нөлөө байсан ч 6 багш гадаадад, 7 багш дотоодын богино хугацааны сургалтад хамрагдсан.
- АНУ-ын Махараши Их Сургуульд “программ хангамж” мэргэжлээр төгсөгч хөнгөлөлттэй нөхцөлөөр магистрт суралцах гэрээг 2021 онд байгуулсан бөгөөд суралцагчдын хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд анхааран ажиллаж байна.
- Төгсөгчдийн холбоо нь байнгын үйл ажиллагаатай бөгөөд Sandbox программчлалын клубийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог. Төгсөгчдийн холбоо нь жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг тогтмол гаргадаг.

**Анхаарах асуудал:**

- Төгсөгчдийн давтан сургалт, дараагийн шатны сургалтад хамрагдах хүрээг өргөжүүлэх
- Гадаадын их сургуультай хамтарч "Оюутан солилцооны хөтөлбөр", "Хос диплом олгох хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх

**Зөвлөмж:**

- Гадаадын их сургуулиудтай хамтын ажиллагааг өргөжүүлэхээс гадна "Программ хангамж" хөтөлбөр хэрэгжүүлдэг Монголын томоохон их сургуулиудын мэргэжлийн багш нартай хамтарч ажиллах, туршлага судлах, хамтарч эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх

**Шалгуурыг хангасан байдал: <u>Бүрэн хангасан</u>**

**4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

**Илрэл нотолгоо:**

- Мэдээлэл, технологийн сургуулийн 2017-2022 оны үйл ажиллагааны төсөв, зарцуулалтын тайлан
- Мэдээлэл, технологийн сургуулийн 2017-2022 оны үйл ажиллагааны зардлын задаргаа
- "Программ хангамж" хөтөлбөрийн 2017-2022 оны Сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан оюутнуудын бүртгэл, судалгаа
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан
- Нэг суралцагчид ногдох өртөг, зардлын тооцоо
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа

**Онцлог зүйл:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Мэдээлэл, технологийн сургууль нь санхүүгийн хувьд Мандах ИС-аас хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулж байна.
- Сургуулийн санхүүгийн албанаас хугарлын цэгийн шинжилгээг гүйцэтгэж төлөвлөлтдөө ашиглахаас гадна нэг суралцагчид ногдох өртөг зардлын тооцоог гүйцэтгэсэн.
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгааг гүйцэтгэсэн. Сургалт, эрдэм шинжилгээ, багшийн хөгжилд зориулсан төсөв, гүйцэтгэлийн хэмжээ жил бүр өссөн дүнтэй.

**Анхаарах асуудал:**

- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын талаар нарийвчилсан судалгааг гүйцэтгээгүй.
- Төрийн байгууллагуудаас зарладаг зөвлөх үйлчилгээний тендер, ШУТС-ийн төслийн шалгаруулалт гэх мэт зөвлөх үйлчилгээнд төслийн санал боловсруулдаг байх

**Зөвлөмж:**

- Сургалтын төлбөрөөс орлогын эх үүсвэрээ бүрдүүлж байгаа хувь хэмжээг бууруулж санхүүжилтийн олон талт эх үүсвэрийг бүрдүүлэх
- Багш нарын бүтээсэн программ, апп-ыг зах зээлд борлуулах замаар эдийн засгийн эргэлтэд оруулах. Тухайлбал: Mtax апп, гар утасны тоглоом гэх мэт.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- Мандах ИС-ийн Маркетингийн албаны төлөвлөгөө, тайлангууд
- Мандах ИС-ийн "Меркадо" ХХК-тай хамтран ажиллах Түншлэлийн гэрээ
- Мэдээлэл, технологийн сургуулиас "Логикийн олимпиад"-ыг зохион байгуулсан тайлан
- Мандах ИС-ийн бренд бүтээгдэхүүний танилцуулга
- Мандах ИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт оюутан элсүүлэх журам

**Онцлог зүйл:**

- Мандах ИС-аас жил бүр "Маркетингийн комисс"-ыг шинэчлэн батлахаас гадна мэргэжлийн байгууллага болох "Mercado" компаниар хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгаа хийлгэж Маркетингийн төлөвлөлт, идэвхжүүлэлтийг гүйцэтгэдэг.
- Улсын хэмжээний "программ хангамж"-ийн олимпиадад тус хөтөлбөрийн оюутнууд "хүрэл медаль" хүртсэн нь элсэлтийн үр дүнтэй маркетингийн идэвхжүүлэлт болно.
- "Программ хангамж" хөтөлбөрийн хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт өндөр тул элсэгчдийн ЭЕШ оноо харьцангуй өндөр байдаг. Маркетингийн идэвхжүүлэлтийг зорилтот зах зээл болох ЕБС төгсөх ангийнханд зориулдаг.

**Анхаарах асуудал:**

- Маркетингийн идэвхжүүлэлтийг жилийн турш тасралтгүй явуулах

**Зөвлөмж:**

- ЕБС-ийн төгсөх ангийнханд зориулж ЭЕШ-д бэлтгэх апп хөгжүүлэх, хичээл заах зэргээр өндөр оноотой элсэгчдийн тоог нэмэгдүүлэх

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Мандах ИС-ийн багшийн хөдөлмөрийг үнэлэх журам
- Мандах ИС-ийн оролцогч талуудаас судалгаа авах журам
- Мандах ИС-ийн Эрдмийн зөвлөлийн тогтоол, шийдвэрүүд
- Мандах ИС-ийн захирлын "Удирдлагын мэдээллийн систем нэвтрүүлэх тухай" тушаал
- Мандах ИС-ийн элсэлтийн үйл ажиллагаа зохион байгуулсан тухай тайлангууд
- Элсэлтийн онлайн программ: www.elselt.mandakh.mn
- Багшийн вэб: e.mandakh.edu.mn
- Оюутны вэб: www.student.mandakh.or, e.mandakh.edu.mn
- Мүүдле программ: www.online.mandakh.org
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлагын үзэсгэлэн танилцуулга

**Онцлог зүйл:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч сургуулиас цахим сайт, хэвлэмэл бүтээгдэхүүн, SANDBOX клуб, гэрээт Маркетингийн байгууллага болох “Mercado” компани зэрэг мэдээллийн эх үүсвэрүүдийг ашиглан хөтөлбөрийн мэдээллийг олон нийтэд түгээдэг.
- Анги даасан багш нар оюутнуудынхаа сурлага, хүмүүжилд анхаарч тэдний эцэг, эхтэй байнга холбогдож мэдээллээр хангадаг.

**Анхаарах асуудал:**

- Оюутнуудын эцэг, эхтэй утсаар ярьж холбогдохоос гадна тэдэнд цахимаар хувь хүний нууцлалыг хадгалсан байдлаар мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэх

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрт оролцогч талуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааг нэгтгэн хэвлэмэл бүтээгдэхүүн болгож олны хүртээл болгох
- Хөтөлбөрт оролцогч талуудаас авсан санал, асуулгын дүнд үндэслэн хийсэн ажлуудыг цахим мэдээллийн санд байршуулдаг байх

**Шалгуурыг хангасан байдал: <u>Бүрэн хангасан</u>**

**4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: <u>Бүрэн хангасан</u>**

## Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

*Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог хангаан бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.*

**5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Мандах ИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт оюутан элсүүлэх журам
- Мандах ИС-ийн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан тухай тайлангууд
- Элсэлтийн онлайн программ: www.elselt.mandakh.mn
- Шинэ элсэгчдэд зориулсан мэдээллийг олон нийтийн мэдээллийн сувгаар ил тод хүргэдэг
- Элсэгчдийн бүртгэлийн мэдээлэл

**Онцлог зүйл:**

- 2020 оноос эхлэн элсэлтийн үйл ажиллагааг www.elselt.mandakh.mn веб хуудсаар дамжуулан 100% цахим хэлбэрээр зохион байгуулж эхэлсэн
- Сүүлийн 2 жилд элссэн элсэгчдийн тоо болон ЭЕШ-ийн дундаж оноо (2021-2022 онд 510.2) өссөн үзүүлттэй байна
- Элсэгчдэд ЭЕШ-ийн онооны дунджаас хамааруулан шинэ элсэгчдийг дэмжих тэтгэлэг олгодог

**Зөвлөмж:**

- Элсэгчдийн тоог нэмэгдүүлэхийн тулд ЕБС-ийн сурагчдад зориулан мэргэжил сурталчлах өдөрлөг болон сургалтын тэтгэлэг, сургуулийн онцлог давуу талыг харуулсан үйл ажиллагаа зохион байгуулах
- Гадаад оюутан элсүүлэх талаар судлах
- Сургуулийн нэрэмжит уралдаан, тэмцээн зохион байгуулах

**Шалгуурыг хангасан байдал: <u>Бүрэн хангасан</u>**

**5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Мандах ИС-ийн Багшийн хөдөлмөрийн үнэлэх журам
- МТС-ийн Сургалтын албаны ажлын төлөвлөгөө, тайлан
- Мандах ИС-ийн багшийн хөдөлмөрийг үнэлэх журам
- Зөвлөх багшийн ажлын тайлан, хурлын тэмдэглэл
- Оюутны дотуур байрны багшийн ажлын төлөвлөгөө, тайлан
- Сургалтын албаны үйл ажиллагаа, ангийн зөвлөх багш болон багш нарын мэдээлэл түгээх талаарх сэтгэл ханамжийн судалгаа
- Тусгай хэрэгцээт суралцагчдад үзүүлэх үйлчилгээний талаар багш, ажилтнуудад зориулсан зөвлөмж
- Оюутны төлөвшил, ёс зүй сахилгыг сайжруулах талаар зохион байгуулсан ажлын төлөвлөгөө, тайлан
- Мандах ИС-ийн судалгааны ажил бичих журам
- “Мандах Эрдэм” сэтгүүлийн дугаарууд \англи, монгол хэл дээр\

**Онцлог зүйл:**

- Оюутныг 1-р курст элсэхэд ангийн зөвлөх багшийг томилон ажиллуулдаг. Зөвлөх багш оюутны суралцах үйл явц, сурлагын амжилтыг хичээлийн жилийн улирал бүрээр хянаж, эцэг эхтэй хамтран ажилладаг
